



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/157/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*

*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: Г.Ганцэцэг*

*Утас: 70003775,*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага .....	15
4.3 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС            Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ЗГ                    Засгийн газар

УСНББОУС        Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.15 № 222

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ДОРНОД  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Х.ДАШДОРЖ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ 011020983

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>170,998,082.25</u></b>	<b><u>191,623,390.46</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	170,998,082.25	191,623,390.46
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	163,438,082.25	184,943,390.46
35410	Бичиг хэргийн материал	546,500.00	540,500.00
35420	Аж ахуйн материал	11,154,840.68	22,263,340.68
35470	Бусад хангамжийн материал	151,736,741.57	162,139,549.78
35600	Мал амьтад	7,560,000.00	6,680,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>401,502,603.28</u></b>	<b><u>378,703,400.51</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	401,502,603.28	378,703,400.51
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	365,964,603.28	343,365,400.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	169,359,912.06	169,359,912.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,075,514.22)	(19,614,587.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	332,361,963.20	332,361,963.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(216,270,974.75)	(253,870,859.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,320,779.67	94,320,779.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,669,216.66)	(81,750,318.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,075,830.43	42,075,830.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,191,301.22)	(24,113,501.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,411,497.63	119,405,578.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,358,372.86)	(34,809,397.19)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,538,000.00	35,337,999.96
39301	Программ хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(200,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,938,000.00	34,938,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>572,500,685.53</u></b>	<b><u>570,326,790.97</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>=</b>	<b><u>760,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	760,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	760,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	760,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>572,500,685.53</u></b>	<b><u>569,566,790.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	572,500,685.53	569,566,790.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	143,013,553.48	143,013,553.48
51101	Өмч: - төрийн	143,013,553.48	143,013,553.48
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	325,118,334.03	322,184,439.47
51210	Өмнөх үеийн үр дүн	325,118,334.03	325,118,334.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,933,894.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,368,798.02	104,368,798.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>572,500,685.53</u></b>	<b><u>570,326,790.97</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>509,591,847.42</b>	<b>448,930,281.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>126,954,697.42</b>	<b>85,494,081.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	126,954,697.42	85,494,081.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,954,697.42	85,494,081.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,529,500.00	1,420,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	125,105,197.42	84,074,081.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>382,637,150.00</b>	<b>363,436,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	382,340,900.00	363,029,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,340,900.00	363,029,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	296,250.00	407,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	296,250.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	407,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>528,885,034.71</b>	<b>451,864,175.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>528,885,034.71</b>	<b>451,864,175.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	510,603,645.70	438,914,660.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,577,549.36	215,704,169.22
210101	Үндсэн цалин	159,023,268.72	157,517,599.07
210102	Нэмэгдэл	49,023,869.46	47,237,570.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,243,400.00	10,949,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,287,011.18	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,352,039.48	30,656,600.00
210201	Тэтгэврийн даатгал	21,713,339.48	21,683,445.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,409,800.00	2,160,654.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,700.00	1,843,012.67
210204	Ажилгүйдлийн даатгал	481,900.00	427,587.33
210205	Эрүүл мэндийн даатгал	4,819,300.00	4,541,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,907,576.77	5,349,539.14
210301	Гэрэл, цахилгаан	1,215,920.88	1,120,538.07
210302	Түлш, халаалт	3,784,070.09	3,404,875.07
210303	Цэвэр, бохир ус	907,585.80	824,126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,231,289.23	28,785,790.00
210401	Бичиг хэрэг	767,526.00	735,700.00
210402	Тээвэр, шатахуун	22,153,364.00	20,823,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,299.23	1,050,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,170,100.00	6,175,700.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	-	217,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	217,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,084,903.16	8,361,491.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	741,400.00	762,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,343,503.16	7,599,091.79
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,455,200.00	1,998,000.00
210702	Дотоод албан томилолт	3,455,200.00	1,998,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	65,776,206.15	48,896,676.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,708,780.15	47,737,184.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	232,400.00	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,136.00	245,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	131,900.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	277,656.00

210807	Газрын төлбөр	97,990.00	272,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	143,218,881.55	98,944,593.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	179,200.00	151,310.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	143,039,681.55	98,793,283.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,281,389.01	12,949,515.18
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	18,281,389.01	12,949,515.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,281,389.01	12,949,515.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(19,293,187.29)</b>	<b>(2,933,894.56)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(19,293,187.29)</b>	<b>(2,933,894.56)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	108,075,553.48	50,655,228.70	269,810,148.78	428,540,930.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>108,075,553.48</b>	<b>50,655,228.70</b>	<b>269,810,148.78</b>	428,540,930.96
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	111,469,523.35	111,469,523.35
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>143,013,553.48</b>	<b>104,368,798.02</b>	<b>325,118,334.03</b>	572,500,685.53
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>143,013,553.48</b>	<b>104,368,798.02</b>	<b>325,118,334.03</b>	572,500,685.53
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(2,933,894.56)	(2,933,894.56)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>143,013,553.48</b>	<b>104,368,798.02</b>	<b>322,184,439.47</b>	569,566,790.97

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>384,486,650.00</b>	<b>364,856,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,849,500.00</b>	<b>1,420,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,849,500.00	1,420,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,849,500.00	1,420,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,529,500.00	1,420,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>382,637,150.00</b>	<b>363,436,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	382,340,900.00	363,029,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,340,900.00	363,029,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	296,250.00	407,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	296,250.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	407,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>384,086,650.00</b>	<b>364,856,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>384,086,650.00</b>	<b>364,856,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>365,805,260.99</b>	<b>351,906,684.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,577,549.36	215,704,169.22
210101	Үндсэн цалин	159,023,268.72	157,517,599.07
210102	Нэмэгдэл	49,023,869.46	47,237,570.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,243,400.00	10,949,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,287,011.18	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,352,039.48	30,656,600.00
210201	Тэтгэврийн даатгал	21,713,339.48	21,573,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,409,800.00	2,270,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,700.00	1,816,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	481,900.00	454,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,819,300.00	4,541,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,907,576.77	5,349,539.14
210301	Гэрэл, цахилгаан	1,215,920.88	1,120,538.07
210302	Түлш, халаалт	3,784,070.09	3,404,875.07
210303	Цэвэр, бохир ус	907,585.80	824,126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,488,289.23	19,253,280.00
210401	Бичиг хэрэг	767,526.00	777,600.00
210402	Тээвэр, шатахуун	22,153,364.00	16,146,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,299.23	1,050,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,427,100.00	1,278,200.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	217,800.00	217,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	217,800.00	217,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	741,400.00	762,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	741,400.00	762,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,455,200.00	1,998,000.00
210702	Дотоод албан томилолт	3,455,200.00	1,998,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	70,736,206.15	77,813,586.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,668,780.15	76,651,994.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	232,400.00	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,136.00	247,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	131,900.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	277,656.00
210807	Газрын төлбөр	97,990.00	272,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	329,200.00	151,310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	329,200.00	151,310.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,281,389.01</b>	<b>12,949,515.18</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	18,281,389.01	12,949,515.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,281,389.01	12,949,515.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>400,000.00</u></b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	400,000.00	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	364,329,200.00	351,499,684.82
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	364,329,200.00	351,499,684.82
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,329,200.00	351,499,684.82
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,086,300.00	215,704,169.22
210101	Үндсэн цалин	157,517,600.00	157,517,599.07
210102	Нэмэгдэл	56,080,100.00	47,237,570.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,488,600.00	10,949,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,656,600.00	30,656,600.00
210201	Тэтгэврийн даатгал	21,573,200.00	21,573,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,270,900.00	2,270,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,816,600.00	1,816,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,200.00	454,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,541,700.00	4,541,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,751,900.00	5,349,539.14
210301	Гэрэл, цахилгаан	1,418,800.00	1,120,538.07
210302	Түлш, халаалт	3,411,700.00	3,404,875.07
210303	Цэвэр, бохир ус	921,400.00	824,126.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,256,600.00	19,253,280.00
210401	Бичиг хэрэг	777,600.00	777,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,146,500.00	16,146,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,054,300.00	1,050,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,278,200.00	1,278,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	217,800.00	217,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	217,800.00	217,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	355,400.00	355,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	355,400.00	355,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,984,200.00	1,998,000.00
210702	Дотоод албан томилолт	2,984,200.00	1,998,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	77,869,000.00	77,813,586.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,701,100.00	76,651,994.46
210803	Даатгалын үйлчилгээ	232,400.00	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,700.00	247,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	134,700.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,000.00	277,656.00
210807	Газрын төлбөр	272,100.00	272,100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	151,400.00	151,310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	151,400.00	151,310.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	364,329,200.00	351,499,684.82
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	364,329,200.00	351,499,684.82
131001	Улсын төсвөөс санхүүжих	363,029,200.00	350,199,684.82
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,300,000.00	1,300,000.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>407,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>407,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	407,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	407,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	407,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	407,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	407,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	407,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилт болон шилэн дансны мэдээлэл, зардлын ангиллын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Г.Ганцэцэг, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Тусгай хамгаалалттай газар нутгийн хяналт шалгалт, сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ хийх зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн 384,190.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,684.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,763.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 191,623.4 мянган төгрөг болж 20,625.3 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 793,062.0 мянган төгрөг болж 75,994.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь 75,994.0 мянган төгрөгийн бусад хөрөнгийн худалдан авснаар нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 60,661.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь төсөвт байгууллагын өөрийн орлого тайлант онд буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 77,021.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа, ажил үйлчилгээний зардал буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 364,329.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 364,329.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 364,329.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 363,029.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 363,029.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,420.0 мянган төгрөг, нийт 364,449.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 351,499.7 мянган төгрөг буюу 96.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 12,949.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 407.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 407.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод хамгаалалтын захиргаа нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 зарлагын 6,840.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй байгаа тул Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны

байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 36.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 5.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 30.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### **4.1 Төлбөрийн акт**

1. Сахилгын шийтгэлтэй ажилтанд 395.7 мянган төгрөгийн урамшуулал цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **4.2 Албан шаардлага**

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингаас 286.7 мянган төгрөгийг суутгаж тайлагнасан байна. Энэ нь ХХОАТ-ын 25 дугаар зүйлийн 25.3-д Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Нийт 181 толгой малын бүртгэлийг тайлант оны жилийн эцэст тоолж нас дэвшилтийн тооцоо хийгээгүй, малчинтай байгуулсан гэрээг дүгнээгүй, гэрээний дагуух малын хорогдол 1,360.0 мянган төгрөг, малын нас дэвшигдсэн орлого 3,690.0 мянган төгрөг нийт 5,050.0 мянган төгрөгийн буруу тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэж заасантай нийцэхгүй, бодитой байх ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд :

1. **Зардлын хэмнэлттэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт : МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 " үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах " зүйл заалтын хэрэгжилтийг хангаж удирдлагаас тушаал шийдвэр гаргаж ажиллаагүй.

1.2 Өгсөн зөвлөмж : Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана “ гэж заасны дагуу төсвийн хэмнэлтийг гаргах тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах.

## 2. Зардлын ангилалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт : Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29 ний өдрийн 190 дугаар тушаалын хавсралт Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагааны зорилгоор ашиглахаар худалдан авах багаж, техник хэрэгслийн зардлыг бүртгэх зардалд бичиг хэргийн бараа материалыг бүртгэсэн.

2.2 Өгсөн зөвлөмж : Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу бүртгэлийг хөтлөх.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод хамгаалалтын захиргаа	6	36.3	-	-	1	0.4	2	5.3	3	30.6